



БУЛГАН АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ

2016/3



СТАТИСТИК МЭДЭЭЛЛИЙГ ХЭРХЭН АВАХ ВЭ?

www.1212.mn

СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЛИЙН
НЭГДСЭН САН

www.nso.mn сайтын
Хэрэглэгчийн бүртгэлд
бүртгүүлснээр цахим
хаягаар тогтмол
авч болно.

Monstat ezStat
аппликейшн

1900-1212
Лавлах утас

@statistic_mn

Статистик
мэдээлэл

Үндэсний Статистикийн
Хорооны
НОМЫН САН

Онлайн лавлах
мессенжер
8:30-17:30

ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭГ

ХҮНД СУРТАЛ
АВИЛГА

ҮГҮЙ НЭЭЛТТЭЙ
ХҮРГЭНЭ

ГАРЧИГ

Аргачлалын тайлбар.....	2
Товч танилцуулга.....	6
Үндсэн үзүүлэлтүүд.....	14
I. 1 Хөдөлмөр	15
I. 2 Нийгмийн даатгал, нийгмийн халамж.....	16
I. 3 Эрүүл мэнд	17
I. 4 Гэмт хэрэг	17
II.2 Үнэ.....	19
II.6 Аж үйлдвэр.....	26
II.6 Мал аж ахуй.....	27

Аргачлалын тайлбар

Хөдөлмөр

Бүртгэлтэй ажилгүй иргэдэд Монгол Улсын хуулиар зөвшөөрөгдсөн хөдөлмөрлөх насны, хөдөлмөр эрхлэх чадвартай, цалин хөлстэй ажил болон хувиараа хөдөлмөр эрхлэгдэггүй, тухайн үед ажиллахад бэлэн, цалин хөлстэй ажил идэвхитэй хайж байгаа хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс, хөдөлмөрийн төв бирж, хөдөлмөрийн хувийн биржид бүртгүүлсэн ажилгүй иргэдийг хамруулна.

Нийгмийн даатгал, халамж

Нийгмийн даатгал нь иргэн болон төр, аж ахуйн нэгж байгууллагаас зохих журмын дагуу шимтгэл төлж, нийгмийн даатгалын сан бүрдүүлэх, даатгуулах, өндөр наслах, хөдөлмөрийн чадвараа алдах, өвчлөх, ажилгүй болоход өөрт нь, тэрчлэн даатгуулагч нас барахад түүний асрамжид байсан хүмүүст хууль тогтоомжид заасан тэтгэвэр, тэтгэмж, төлбөр өгөх агуулга бүхий нийгэм эдийн засгийн арга хэмжээ юм. Тэтгэврийн, тэтгэмжийн, эрүүл мэндийн, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалан өвчний, ажилгүйдлийн даатгал гэсэн төрлөөс нийгмийн даатгал бүрдэнэ.

Нийгмийн даатгалын сан нь ажил олгогч, даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, үйлчилгээнд зарцуулах болон нийгмийн даатгалын үйл ажиллагааны зардлыг нөхөх зорилгоор төлсөн шимтгэлийн орлого, бусад эх үүсвэрээс бүрдэнэ.

Нийгмийн даатгалын тухай хууль болон гэрээний үндсэн дээр нийгмийн даатгалын санд нийгмийн даатгалын шимтгэл төлж даатгуулсан, нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авах эрх бүхий этгээдийг даатгуулагчаар тооцно.

Тэтгэвэр нь даатгуулагчийг өндөр наслахад насан туршид нь, хөгжлийн бэрхшээлтэй болоход хөдөлмөрийн чадвар нь сэргээгдэх хүртэл, нас барахад нь түүний гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй гишүүд (хүүхэд 16 нас, сургуульд суралцаж байгаа бол 19 нас хүртэл)-ийн нийгмийн баталгааг хангах зорилгоор нийгмийн даатгалын сангаас олгох мөнгөн хөрөнгө байна.

Тэтгэмж нь хөдөлмөрийн чадвараа түр алдах, жирэмслэх, амаржих, нас барах тохиолдолд даатгуулагчид нийгмийн даатгалын сангаас нэг удаа олгох мөнгөн хөрөнгө байна.

Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа шаардлагатай хүнд хуульд заасан тэтгэвэр, нөхцөлт мөнгөн тэтгэмж олгох, олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн болон төрөлжсөн асрамжийн үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг нийгмийн халамж гэнэ.

Эрүүл мэнд

Жирэмслэлтийн хугацаанаас хамаарахгүйгээр ердийн төрөлтөөр эсвэл мэс ажилбараар ургийг умайнаас гарган авсны дараа нярай амьсгалж байсан эсвэл амьдын бусад ямар нэгэн шинж тэмдэг, өөрөөр хэлбэл, зүрхний цохилт, хүйний судасны лугшилт, булчингийн тодорхой хөдөлгөөн илэрч байвал хүй эсвэл эхэсийг салгасан эсэхийг харгалзахгүйгээр амьд төрөлтөд тооцно.

Амьд төрсөн 1000 хүүхдэд ногдох нялхсын эндэгдлийг тодорхойлохдоо тухайн хугацаанд 1 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулна.

Амьд төрсөн 1000 хүүхдэд ногдох хүүхдийн эндэгдлийг тооцохдоо тухайн хугацаанд 5 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд хуваана.

Эндсэн эхийн тоонд жирэмсний хугацаанд болон төрөх үедээ эсвэл төрснөөс хойш 42 хоногийн дотор жирэмслэлтийн байрлал, үргэлжилсэн хугацаанаас үл хамааран жирэмслэлт, төрөлт болон түүнийг удирдахтай холбоо бүхий шалтгаанаар эндсэн эхийг хамааруулна.

Халдварт өвчний өвчлөлийн 10000 хүнд ногдох түвшинг тооцохдоо тайлант хугацаанд амбулаторийн үзлэгээр шинээр бүртгэгдсэн нийт халдварт өвчний тохиодлын тоог тухайн хугацааны хүн амын тоонд харьцуулна.

Аюулт үзэгдэл, осол

Гамшиг гэж аюулт үзэгдэл, техникийн холбогдолтой осол, алан хядах ажиллагаа, дэлбэрэлтийн улмаас олон хүний эрүүл мэнд, амь нас хохирох, мал амьтан олноор хорогдох, эд хөрөнгө, хүрээлэн байгаа орчинд улс, орон нутгийн дотоод нөөц боломжоос давсан хохирол учрахыг хэлнэ.

Аюулт үзэгдэл гэж хүчтэй цасан болон шроон шуурга, ган, зуд, үер, газар хөдлөлт, цөлжилт болох, гал түймэр, хүн, мал, амьтны болон ургамлын гоц халдварт өвчин гарах, хортон мэрэгчид тархах зэргийг хамруулан ойлгоно. Техникийн холбогдолтой осол гэж үйлдвэрлэл, технологийн горим зөрчигдсөнөөс тоног төхөөрөмж, барилга, байгууламж, шугам, сүлжээ эвдрэх, тээврийн хэрэгсэл осолдох, сүйрэх, цацраг идэвхт болон химийн хорт бодис алдагдах зэргийг хамруулан ойлгоно.

Гэмт хэрэг

Эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр Монгол Улсын Эрүүгийн хуульд заасан, нийгэмд аюултай, гэм буруутай үйлдэл, эс үйлдэхгүйг гэмт хэрэг гэнэ.

Гэмт хэргийн нийгмийн шинж чанар, аюулын хэр хэмжээ, оногдуулж болох ялын хүнд хөнгөнийг харгалзан гэмт хэргийг хөнгөн, хүндэвтэр, хүнд, онц хүнд гэж ангилна.

Гэмт хэргийн тоог Монгол Улсын Эрүүгийн хуульд заасны дагуу гэмт хэргийн төрлөөр нэгтгэн гаргаж байна.

Тухайлбал:

- Хүний ам бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг
- Хүүхэд гэр бүл, нийгмийн эсрэг гэмт хэрэг
- Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг
- Үндэсний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг
- Нийгмийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг
- Хүн амын эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг
- Тээврийн хэрэгслийн хөдөлгөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг
- Шүүн таслах ажиллагааны эсрэг гэмт хэрэг
- Байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэрэг
- Бусад гэмт хэрэг

18 ба түүнээс дээш насны 10000 хүнд ногдох бүртгэгдсэн гэмт хэргийн тоог тодорхойлохдоо нийт бүртгэгдсэн гэмт хэргийн тоог 18 ба түүнээс дээш насны хүн амын дундаж тоонд харьцуулна.

Дор дурьдсан этгээдэд хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч эрүүгийн хэрэг үүсгэж, үндэслэл бүхий тогтоол гаргасан бол сэжигтнээр тооцно. Үүнд:

-Уг этгээдийг гэмт хэрэг үйлдэж байх үед буюу үйлдэл дор нь барьсан

-Гэмт хэрэг үйлдсэн этгээдийг хохирогч буюу харсан хүн шууд заасан

-Уг этгээдийн бие, хувцас, эд зүйл, орон байранд гэмт хэргийн ул мөр тодорхой илэрч олдсон

-Уг этгээд хэргээ илчлэн ирсэн

-Гэмт хэрэгт сэрдэгдэх үндэслэл бүхий бусад баримт байгаа бол

Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч тогтоол үйлдэж, ял сонсгосон этгээдийг яллагдагчаар тооцно.

Төрийн санхүү

Орон нутгийн төсвийн суурь орлого гэж тухайн шатны төсөвт орох татварыг доод хувь хэмжээгээр тооцсон орлого болон татварын бус орлогын нийлбэрийг хэлнэ.

Орон нутгийн суурь зарлага гэж сум, аймаг, нийслэлийн удирдлагыг хэрэгжүүлэх чиг үүрэгтэй холбогдох урсгал болон хөрөнгийн зарлага, нийгмийн асрамж, халамжийн үйлчилгээ, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх зардлыг хэлнэ.

Төсвийн тэнцэл гэж тухайн төсвийн жил, улирлын нийт орлого, зарлагын зөрүүг хэлнэ.

Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас батлан аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга бүрдүүлж зарцуулах төсөв нь орон нутгийн төсөв байна.

Татварын орлогод орлогын албан татвар, нийгмийн даатгалын шимтгэл, хураамж, өмчийн татвар, дотоодын бараа, үйлчилгээний татвар, гадаад худалдааны татварын орлого болон бусад татвар орно.

Төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжийн төрийн өмчид ногдох хувьцааны ногдол ашиг, хүү, торгуулийн орлого, түрээсийн орлого, төсөвт газрын өөрийн орлого болон татварын бус бусад орлогоос татварын бус орлого бүрдэнэ.

Төсвийн зарлагыг урсгал зардал, хөрөнгийн зардал, цэвэр зээл гэж ангилна.

Бараа, үйлчилгээний зардал, зээлийн үйлчилгээний төлбөр, татаас ба урсгал шилжүүлгээс урсгал зардал бүрдэнэ.

Үнэ

Хэрэглээний үнийн индекс (ХҮИ) нь хэрэглэгчдийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нэр төрөл, чанар өөрчлөлтгүй тогтвортой байхад үнэ дунджаар хэрхэн

өөрчлөгдөж буйг хэмжих үзүүлэлт бөгөөд нийт өрхөөр тооцсон үнийн өөрчлөлтийг харуулна.

ХҮИ-ийн тооцоонд хэрэглээний сагс, хэрэглээний жин гэсэн хоёр үзүүлэлтийг ашиглана.

Хэрэглээний сагс нь дундаж зарлагатай өрхийн хэрэглээг төлөөлөх чадвартай, хэрэглээний үнийн индекс тооцох зорилгоор бүрдүүлсэн хүн амын өргөн хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн өөрчлөлтийг тооцоход бараа, үйлчилгээний тоо хэмжээ, төрөл, чанар зэргийг тогтмолоор авч үздэг.

Хэрэглээний бараа үйлчилгээний жин гэж өрхийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нийт зардалд тухайн бараа, үйлчилгээний зардлын эзлэх хувийн жин юм.

ХҮИ-ийн тооцоонд Ласпейресийн үнийн индексийн томъёог ашиглаж болно.

$$I_p^L = \frac{\sum_{i=1}^n p_{it} * q_{io}}{\sum_{i=1}^n p_{io} * q_{io}}$$

I_p^L - t тайлант үеийн Ласпейресийн үнийн индекс

t - тайлан үе

o - суурь үе

p_{it} - 'i' барааны тайлант үеийн үнэ,

p_{io} - 'i' барааны суурь үеийн үнэ,

q_{io} - 'i' барааны суурь үеийн худалдан авсан тоо, хэмжээ,

\sum - нийлбэрийн тэмдэг

Аж үйлдвэр

Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл нь аж ахуйн нэгжүүдийн тайлант хугацаанд зах зээлд болон өөрийн эцсийн хэрэглээнд зориулж үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээс бүрдэнэ.

Аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн нь аж ахуйн нэгжүүдийн

тайлант хугацаанд худалдсан буюу гадагш гүйцэтгэсэн ажил, үйлчилгээний хэмжээ юм.

Аж ахуйн нэгжүүдийг эдийн засгийн үйл ажиллагаагаар нь ангилахдаа НҮБ-аас гишүүн орнууддаа мөрдөхийг зөвлөмж болгосон эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны олон улсын стандарт ангилалд үндэслэсэн үндэсний ангиллыг мөрдөж байна.

Ерөнхий тэмдэглэл

I. Саруудыг ром тоогоор тэмдэглэв (I, II, III, IV, V, ... гэх мэт)

Тухайн сарыг оруулсан жилийн эхнээс өсөн нэмэгдэх дүнг харуулахдаа I-IV, I-X зэргээр илэрхийлэв.

II. Дараах тэмдэглэлийг ашиглав:

... мэдээлэл байхгүй

0.0 маш бага тоо

- гүйцэтгэл байхгүй

III. Орон дэвшүүлэлтээс хамаарч зарим үзүүлэлтийн нийлбэр нь дүнтэйгээ, бүтцийг хувиар илэрхийлэхэд 100 хувиас бага зэрэг зөрүүтэй байж болно.

I. Нийгмийн үзүүлэлт




I.1 Хүн ам

Аймгийн хэмжээнд 2016 оны 1-р улирлын байдлаар 222 хүүхэд мэндэлж, 85 хүн нас барсан нь өмнөх оний мөн үеийнхээс төрөлт 53 хүүхэд буюу 23.7 хувиар, нас баралт 3 хүн буюу 4 хувиар тус тус буурсан байна.

Зураг I.1


Төрөл, нас баралт, ердийн өсөлт оноор



1-р улирлын байдлаар 282 хүн шилжин ирж, 378 хүн шилжин явсан нь өмнөх оны мөн үеийнхээс шилжин ирсэн хүн 2 буюу 0.5 хувиар, шилжин явсан хүн 66 буюу 30 хувиар тус буурсан байна.

Зураг I.2

Шилжих хөдөлгөөн, механик өсөлт, оноор



I.2 Бүртгэлтэй, ажилгүй иргэн

Аймгийн хөдөлмөрийн хэлтэст бүртгүүлсэн ажил хайгч иргэд 2016 оны 3 дугаар сарын байдлаар 442 болсны 213 нь эмэгтэйчүүд байна.

Тайлант хугацаанд 481 иргэн шинээр бүртгүүлж, бүртгэлтэй байсан 18 иргэн ажилд зуучлагдан орж, 159 иргэн ажил идэвхитэй хайхгүй байгаа шалтгаанаар бүртгэлээс хасагдсан нь өмнөх оны мөн үеийнхээс шинээр бүртгүүлсэн ажилгүй иргэнд 284 хүн буюу 44.1 хувиар өсч, ажилд

зуучлагдан орсон иргэд 9 хүн буюу 33.3 хувь, ажил идэвхитэй хайхгүй байгаа шалтгаанаар бүртгэлээс хасагдсан иргэд 191 хүнээр буюу 54.6 хувиар буурчээ.

Зураг I.3

Хөдөлмөрийн хэлтэст шинээр бүртгүүлсэн, ажилд зуучлагдан орсон иргэд 3 дугаар сарын байдлаар



Бүртгэлтэй ажилгүй иргэдийн 0.1 хувийг Магистр болон докторын зэрэгтэй, 20.3 хувийг бакалаврын болон дипломын боловсролтой, 5.9 хувийг тусгай мэргэжлийн дунд, 9.3 хувийг техникийн болон мэргэжлийн, 50.3 хувийг бүрэн дунд боловсролтой, 9.9 хувийг суурь боловсролтой, 3.4 хувийг бага боловсролтой, 0.8 хувийг боловсролгүй иргэд эзэлж байна.

Зураг I.4

Бүртгэлтэй ажилгүй иргэд, боловсролын түвшнээр 2016 оны 3 дугаар сарын байдлаар, хувиар



Эх үүсвэр: Хөдөлмөрийн хэлтсийн сар бүрийн мэдээ

Аймгийн хэмжээнд бүртгэлтэй ажилгүй иргэдийн 18.8 хувийг 15-24 насны, 36.0 хувийг 25-34 насны, 22.4 хувийг 35-44 насны, 16.9 хувийг 45-54 насны, 3.9 хувийг 55-59 насны, 2.0 хувийг 60-аас дээш насны хүмүүс эзэлж байна.



I.3. Нийгмийн даатгал, халамж

Нийгмийн даатгал

Нийгмийн даатгалын сангийн орлого 2016 оны 3 сард 2686.4 сая төгрөг, зарлага 7371.5 сая төг болж өмнөх оны мөн үеийнхээс орлого 37.6 сая төг буюу 1.4 хувиар буурч, зарлага 728 сая төг буюу 11 хувиар өслөө. Нийгмийн даатгалын сангийн орлого 37.6 сая төгрөгөөр буурхад тэтгэмжийн даатгалын сангийн орлого 11.2 сая.төг буюу 5.5 хувиар, ажилгүйдлийн даатгалын сан 1.3 сая.төг буюу 2.6 хувиар, тэтгэврийн даатгалын сангийн орлого 117.9 сая.төг буюу 6.7 хувиар буурсан нь голлон нөлөөлсөн байна. Нийгмийн даатгалын сангийн зарлага өмнөх оны мөн үеийнхээс 728 сая.төг буюу 11 хувиар нэмэгдэхэд тэтгэврийн даатгалын сангийн зарлага 498.2 сая.төг буюу 8.3 хувиар, ҮОМШӨ даатгалын сан 48.7 сая.төг буюу 93.7 хувиар, эрүүл мэндийн даатгалын сан 178.1 сая.төг буюу 58.1 хувиар өссөн нь голлон нөлөөлөв. Харин тэтгэмжийн даатгалын сан 29.1 сая.төг буюу 10.8 хувиар буурсан байна.

Нийгмийн халамж

Нийгмийн халамжийн сангаас 2016 оны 3 сард 874.4 сая төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж олгосон бөгөөд өмнөх оны мөн үеийнхээс 38.4 сая.төг буюу 4.6 хувиар өсчээ. Үүний 12.9 сая. төг буюу 3.2 хувийг халамжийн тэтгэвэр, 22.1 сая.төг буюу 7.4 хувийг нь нөхцөлт мөнгөн тэтгэмжинд зарцуулсан байна. Халамжийн сангаас олгосон нөхцөлт мөнгөн тэтгэмжийн 28.1 хувийг ахмад настанг асарч буй иргэнд олгосон тэтгэмж, 9.2 хувийг хөгжлийн бэрхшээлтэй иргэнд олгосон тэтгэмж, 5.4 хувийг бүтэн өнчин хүүхэд өсөгсөний тэтгэмж эзэлж байна.




I.4 Эрүүл мэнд

Аймгийн хэмжээнд 2016 оны 1-р улирлын байдлаар 221 эх амаржиж, амьд төрсөн хүүхдийн тоо 222 болж, өмнөх оны мөн үеийнхээс амаржсан эхийн тоо 55 буюу 24 хувь, амьд төрсөн хүүхдийн тоо 53 буюу 23 хувиар буурсан байна

Зураг I.3


Амаржсан эх, амьд төрсөн хүүхэд, сүүлийн 3 жилийн 1-р улирлын байдлаар



Аймгийн хэмжээнд нялхасын эндэгдэл 2016 оны эхний 1 улирлын байдлаар 3 болж, өмнөх оны мөн үеийнхээс 2 буюу 60 хувиар буурсан байна.

Зураг I.4


Эндсэн хүүхэд, сүүлийн 3 жилийн 1-р улирлын байдлаар




Халдварт өвчнөөр өвчлөгсөд 2016 оны 1-р улирлын байдлаар 183 болж, өмнөх оны мөн үеийнхээс 77 тохиолдол буюу 42 хувиар өссөн байна. Нийт халдварт өвчнөөр өвчлөгсдийн 126 буюу 69 амьсгалын замын халдварт өвчин, 45 буюу 26 хувь нь бэлэгсийн замын халдварт өвчнөөр өвчилсөн байна.

Зураг I.5

Халдварт өвчнөөр өвчлөгсөд, сүүлийн 3 жилийн 3-р сарын байдлаар





1.5 Байгаль орчин

Цаг уурын урьдчилсан мэдээ

Дөрөвдүгээр сард. Энэ сард агаарын дундаж температур 2-7 градус дулаан байх ба уур амьсгалын дунджийн орчим байх төлөвтэй.


Сарын эхэн болон 8-10-н, сарын дунд үе ба 18-20-нд хүйтэрч шөнөдөө 6-11 градус хүйтэн, өдөртөө 1-6 градус дулаан байна. Сарын эцсээр хүйтэрнэ. Харин 4-6-н ба 24-26-нд харьцангуй дулаарч шөнөдөө 2 градус хүйтнээс 3 градус дулаан, өдөртөө Орхон-Сэлэнгийн хөндийгөөр 19-24 градус, бусад нутгаар 15-20 градус дулаан байна. Бусад хугацаанд шөнөдөө 3-8 градус хүйтэн, өдөртөө 10-15 градус дулаан, зарим газраар 15-20 градус дулаан байна.

Энэ сард орох хур тунадасны хэмжээ нь нутгийн өмнөд хэсгээр уур амьсгалын дунджаас бага, бусад нутгаар олон жилийн дунджийн орчим байх төлөвтэй.

Сарын эхээр зарим газраар, 8-10-нд ихэнх нутгаар цас, сарын дунд үе болон 18-20-нд зарим газраар, 24-26-нд нутгийн хойд хэсгээр, сарын эцсээр ихэнх нутгаар хур тунадас, уулаараа нойтон цас орох төлөвтэй. Энэ үеүдэд салхи зарим газраар 14-16м/с, ялангуяа 8-10, сарын дунд үе ба 24-26-н болон сарын сүүлчээр нутгийн өмнөд хэсгээр 18-20 м/с хүртэл ширүүсч шороон ба цасан шуурга шуурна.

Зураг 1.6

2-р сарын агаарын температурын хоногийн явц



Тавдугаар сард. Агаарын температурын сарын дундаж нь уур амьсгалын дунджийн орчим байх төлөвтэй.

Энэ сард ихэнх нутгаар уур амьсгалын дунджаас ахиу, бусад нутгаар дунджийн орчим хур тунадас орох төлөвтэй

Зургаадугаар сард. Агаарын температурын сарын дундаж нь нутгийн хойд хэсгээр уур амьсгалын дунджаас 0.5-1.0 градусаар

дулаан, бусад нутгаар дунджийн орчим байх төлөвтэй.

Энэ сард нийт нутгаар уур амьсгалын дунджийн орчим хур тунадас орох төлөвтэй.

Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд хэрхэн нөлөөлөх талаар:

4 дүгээр сарын цаг агаарын урьдчилсан мэдээгээр агаарын дундаж температур нийт нутгаар дунджийн орчим, хур тунадас нутгийн баруун өмнөд хэсгээр олон жилийн дунджаас бага бусад нутгаар дунджийн орчим орох төлөвтэй байна.

4 дүгээр сард дулаан, тунадас дунджийн орчим орох төлөвтэй газраар бэлчээрийн ургамал эрт цухуйж, хөрс эрт гэсэж газар тариаланд таатай нөлөөлөхөөр байна. Түүнчлэн 4 дүгээр сард үе үе хүчтэй цасан болон шороон шуурга шуурч малын хариулга маллагаа болон төл хүлээн авахад хүндрэл учруулж болзошгүйг онцгой анхаарна уу

Аюулт үзэгдэл, осол

Аюулт үзэгдэл, осол 2016 оны 3 дугаар сард 22 удаа гарч, 2 хүн амь насаа алдаж, 25.6 мян. толгой мал, амьтан хорогджээ. Харин объектын түймэр 5 удаа гарсан байна. Тайлант хугацаанд нийт 5 удаа гэр, авто машин шатжээ.

Аймгийн хэмжээнд энэ улирлын байдлаар 194335.8 мян.төгрөгийн хохирол учирсан нь өмнөх оны мөн үеийнхээс 94732.1 мян. төгрөгөөр буурсан байна.

Хорогдсон, устгасан мал тэжээвэр амьтад өмнөх оны мөн үеийнхээс 25.1 мян толгойгоор нэмэгдсэн шалтгаан нь байгаль цаг уурын өөрчлөлт зудын байдалтай холбоотой юм байна.

Зураг 1.6

Аюулт үзэгдэл, ослын тохиолдол болон объектын гал түймрийн тоо 3 дугаар сарын байдлаар



Хүснэгт I.6 Аюулт үзэгдэл, осол 1-р улирлын байдлаар

Үзүүлэлт	2014 I-III	2015 I-III	2016 I-III	2016 I-III 2015 I-III
Аюулт үзэгдэл, ослын тохиолдлын тоо	25	31	22	71.0
Аюулт үзэгдэл, ослын улмаас ам насаа алдсан хүний тоо	0	1	2	200.0
Шатсан гэр, орон сууц, авто машины тоо	9	12	5	41.7
Аюулт үзэгдлийн улмаас хорогдсон, устгасан мал тэжээвэр амьтан, толгой	20	434	25584	5894.9
Объектын гал түймрийн тоо	10	13	5	38.5
Учирсан хохирлын хэмжээ, мян.төг	141179	289068	194336	67

Эх үүсвэр: Онцгой байдлын газрын улирлын мэдээ




I.6 Гэмт хэрэг

Аймгийн хэмжээнд 2016 оны эхний улирлын байдлаар 75 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 5 хэргээр буюу 6.3 хувиар буурсан байна. БҮСТЗЭТХэрэг 27 бүртгэгдэн 14 хэргийг илрүүлэлт 50 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 10.2 хувиар буурсан.

Зураг I.7

Бүртгэгдсэн гэмт хэрэг, жил бүрийн эхний 1-р улирлын байдлаар



Хэргийн өнгөөр нь авч үзвэл

- ИЭЧЭМЭГХ 29 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 4 хэргээр буюу 16 хувиар
- Танхайрах гэмт хэрэг 1 бүртгэгдэж 1 хэргээр буюу 50 хувиар
- Хулгайн гэмт хэрэг 28 бүртгэгдсэн өмнөх оны мөн үеийнхээс 2 хэргээр буюу 6.5 хувиар, үүнээс мал хулгайлах хэрэг 11 бүртгэгдэн өмнөх оны мөн үеийнхээс 11

хэргээр буюу 50.0 хувиар буурчээ.

- Хүнийг санаатай алах гэмт хэрэг 4 бүртгэгдэн өмнөх оны мөн үеийнхээс 100 хувиар

- Хүчиндэх гэмт хэрэг 2 бүртгэгдэн урьд оны мөн үеийнхээс 100 хувиар

- ХАБАЖЭГХ 7 бүртгэгдэж өмнөх оны мөн үеийнхээс 2 хэргээр буюу 40.0 хувиар


- Албан тушаалын эсрэг гэмт хэрэг 2 бүртгэгдсэн өмнөх оны мөн үеийнхээс 100 хувиар тус тус өсчээ.

Гэмт хэргийн улмаас учирсан хохирол

Гэмт хэргийн улсаас нийт иргэд, аж ахуй нэгж байгууллагад 164.8 сая төгрөгний хохирол учирснаас иргэдэд 109.0 сая төгрөгний хохирол учирсан байна. Үүнээс бүртгэлд мөрдөн байцаалтын шатанд 127.2 сая төгрөгний хохирлыг нөхөн төлүүлж ажилласан.

Зураг I.8


Гэмт хэргийн улмаас учирсан хохирол, жил бүрийн эхний 1-р улирлын байдлаар



Гэмт хэргийн улмаас 13 хүн нас барсан ба өнгөрсөн оны мөн үеийнхээс 40 хувиар өссөн байна. Бусдыг амиа хорлоход хүргэх гэмт хэргийн улмаас 4, бусдыг санаатай алах гэмт хэргийн улмаас 1, бусдыг болгоомжгүй алах гэмт хэргийн улмаас 1, ХАБАЖЭГХ –ийн улмаас 4 иргэн тустус амь насаа алдсан байна. Гэмт хэргийн улмаас 38 хүн гэмтсэн нь ИЭЧЭМЭГХ –ын улмаас 21, ХАБАЖЭГХ –ийн улмаас 9 хүн, бусад хэргийн улмаас 8 хүн гэмтсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 2 буюу 5.6 хувиар өссөн байна.

Зураг I.9

Гэмт хэргийн улмаас гэмтсэн, нас барсан, жил бүрийн эхний 1-р улирлын байдлаар



2016 оны эхний 2 сарын байдлаар гудамж талбайд хэвийн бус явж орон гэртээ агсан согтуу тавьсны улмаас 106 хүн эрүүлжүүлэгдсэн нь өмнөх оны мөн үеийхээс 5 хүнээр буюу 5 хувиар буурсан бол, захиргааны журмаар 4 хүнийг баривчилж шийтгэл эдлүүлсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 3 хүнээр буюу 84,6 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодож эрхээ хасуулж торгуулсан 63 иргэн байна.



II. Эдийн засгийн үзүүлэлт


II.1 Аймгийн төсөв

Аймгийн орон нутгийн төсвийн нийт орлого 2016 оны 1-р улирлын байдлаар 11495.6 сая төгрөг, зарлага 10613.6 сая төгрөг болж, аймгийн төсвийн нийт тэнцэл 882 сая төгрөгний эерэг гарлаа.

Орон нутгийн төсвийн орлогын 34 хувийг татварын орлого, 2 хувийг татварын бус орлого, 64 хувийг улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг эзэлж байна. Аймгийн төсвийн зарлагын хэмжээ 2016 оны 1-р улиралд 11495.6 сая.төг болоход 77 хувь буюу 8215.2 бараа материалын зардал, 23 хувь буюу 3280 сая.төг урсгал шилжүүлгийн зардал эзэлж байна.

Зураг II.1


Аймгийн төсвийн орлого, зарлага жил бүрийн 1-р улирлын байдлаар, сая төг



Нийт авлага 38.1 сая, өглөг 754.8 сая төгрөг байна. Нийт өглөгөөс цалин, НДШ-ийн өр 137.9 сая төг, халаалт, гэрэл цахилгаан, цэвэр бохир усны өр 467.9 сая, эмийн өр 6.2 сая, бусад зардлын өглөг 142.8 сая төгрөг байна.

Зураг II.2

Аймгийн төсвийн өр, авлага сараар




II.2 Үнэ Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн индекс аймгийн хэмжээнд 2016 оны 3 дугаар сард өмнөх сарынхаас 0.1 хувь, өмнөх оны эцсийнхээс 0.9 хувь, өмнөх оны мөн үеийнхээс 0.9 хувиар өслөө.

Зураг II.3

Хэрэглээний үнийн аймгийн индекс (суурь үе буюу 2010-XII=100хувь)




Хүснэгт II.1

Хэрэглээний үнийн аймгийн индекс (суурь үе буюу 2010-XII=100хувь)

Бараа, үйлчилгээний бүлэг	Жин	2016 III 2015 III	2016 III 2015 XII	2016 III 2016 II
Ерөнхий индекс	100.0	100.9	100.9	100.1
Хүнсний бараа, ундаа, ус	29.3	99.2	102.9	101.0
Согтууруулах ундаа, тамхи	3.2	101.8	100.2	100.0
Хувцас, бөс, бараа, гутал	16.1	96.6	101.0	100.0
Орон сууц, ус, цахилгаан, түлш	12.3	105.9	101.9	100.0
Гэр ахуйн тавилга, бараа	4.7	100.9	99.0	99.0
Эм тариа, эмнэлэгийн үйлчилгээ	3.6	99.2	100.0	100.0
Тээвэр	12.2	100.0	98.7	100.0
Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ	4.4	99.9	100.0	100.0
Амралт, чөлөөлт цаг, соёлын бараа, үйлчилгээ	2.8	99.4	99.6	99.6
Боловсролын үйлчилгээ	4.7	132.5	100.0	100.0
Зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ	2.6	106.2	100.0	100.0
Бусад бараа, үйлчилгээ	4.1	103.9	101.1	100.0

Зураг II.4

Хэрэглээний бараа үйлчилгээний үнийн индекс, хувь, 2015 оны I-XII сар, (өмнөх сар=100%)



Хөдөө аж ахуйн зарим бүтээгдэхүүний зах зээлийн дундаж үнэ

Мал аж ахуйн бүтээгдэхүүний зах зээлийн үнийн судалгаагаар 2016 оны эхний 2 сард адууны шир 20.0 мян.төгрөг, үхрийн 1.8-2.3 м урттай шир 16.2 мян.төгрөг, 2.3 м-с дээш урттай шир 23.7 мян.төгрөг, хонины нэхий 0.5 мян.төгрөг, ямааны арьс 7.1 мян.төгрөг байна. Өмнөх оны мөн үеийнхээс адууны шир 33.3 хувиар, үхрийн 1.8-2.3 метрийн урттай шир 59.3 хувиар, 2.3 метрийн урттай шир 60.4 хувиар буурсан байна.

Малын дундаж үнэ: 2016 оны 2 сард тэмээ 883 мян.төг, адуу 650 мян.төг, үхэр 863 мян.төг, хонь 123 мян.төг, ямаа 88 мян.төг болж буюу өмнөх оны мөн үеийнхээс тэмээ

10.8 хувиар, адуу 17.2 хувиар, үхэр 18.6 хувиар, хонь 23.1 хувиар, ямаа 16.2 хувиар тус тус буурчээ.



II.3 Худалдан авах ажиллагаа

Аймгийн худалдан авах ажиллагааны алба нь 2016 оны эхний улирлын байдлаар орон нутгийн төсвөөс 2 төсөл арга хэмжээ буюу 100.0 сая.төг, орон нутгийн хөгжлийн сангаас 6 төсөл арга хэмжээ буюу 441 сая.төгрөг, авто замын сангаас 1 төсөл арга хэмжээ буюу 20 сая.төгрөг, байгаль хамгаалах сангаас 5 төсөл арга хэмжээ буюу 922.2 сая.төгрөг, нийт 14 төсөл арга хэмжээ буюу 1483.2 сая төгрөгийн төсөл арга хэмжээ зохион байгуулахаар төлөвлөсөн. Нийт төлөвлөгдсөн 14 төсөл арга хэмжээ тендерт зарлагдаж, 3 төсөл арга хэмжээ гэрээ байгуулсан ба 5 төсөл арга хэмжээ үнэлгээ хийгдсэн байна.

Өмчийн алба

2016 оны эхний улирлын байдлаар аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 4 дэх удаагийн хуралдаанаар давхардсан тоогоор 20-н нэгж, байгууллагын 255.9 сая.төгрөгийн үндсэн хөрөнгийг шийдвэрлэсэн байна. Үүнээс 2 нэгж, байгууллагын 47.1 сая.төгрөгийн хөрөнгийг шилжүүлсэн, 6 нэгж, байгууллагын 7 нэр төрлийн 98.9 сая.төгрөгийн хөрөнгийг акталсан, давхардсан тоогоор 11 нэгж, байгууллагын 99.8 сая.төгрөгийн анхны өртөгтэй хөрөнгийг дуудлага худалдаанд оруулан 1 нэгж, байгууллагын 1.8 сая. төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.



II.4 Аж үйлдвэр

Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 2016 оны 1-р улиралын байдлаар 2191.3 сая. төг болж, өмнөх оны мөн үеийнхээс 776.1 сая.төг буюу 53.8 хувиар өссөн байна. Үүнд уул уурхай, олборлох үйлдвэрийн нийт үйлдвэрлэл 452.4 сая. төг болж өссөн байна

Зураг II.5

Аж үйлдвэрийн салбарын борлуулалт жил бүрийн эхний 3 сарын байдлаар



Аж үйлдвэрийн салбар нь 2016 оны эхний 1-р улиралд 3038.2 сая төгрөгний бүтээгдэхүүн борлуулсан нь өмнөх оны мөн үеийнхээс 363,9 сая.төг буюу 13.6 хувиар өссөн байна. Нийт борлуулалтын 491.2 сая төгрөг буюу 16.2 хувийг уул уурхай салбар, 1570.7 сая төгрөг буюу 51.6 хувийг боловсруулах аж үйлдвэрийн салбар, 976.1 сая төгрөг буюу 32.1 хувийг цахилгаан дулааны үйлдвэрлэлт эзэлж байна.



II.5 Барилга

Барилгын байгууллагууд нь 2016 оны эхний 1-р улиралд 1276.7 сая төгрөгийн барилга угсралт их засварын ажил гүйцэтгэсэн нь өмнөх оны мөн үеэс 278.7 хувиар өссөн байна. Нийт барилга угсралт их засварын ажлын 182.7 сая төгрөг буюу 14.3 хувийг сургууль, 700.0 сая төгрөг буюу 54.8 хувийг спорт, биеийн тамир, 238.0 сая төгрөг буюу 18.6 хувийг конторын, 105.9 сая төгрөг буюу 8.3 хувийг бусад зам талбай, 50.0 сая төгрөг буюу 3.9 хувийг инженерийн барилга байгууламжийн их засварын ажил эзэлж байна. 2016 оны 1-р улиралд барилга угсралт их засварын ажлын гүйцэтгэл 1276.7 сая төгрөг байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 278.7 хувиар өссөн байна. Нийт барилга угсралт их засварын ажлыг төрийн өмчит үйлдвэрийн газар гүйцэтгэсэн байна.

Газар өмчлөл

2016 оны 1-р улирлын байдлаар аймгийн хэмжээнд газар өмчлөхөөр 54 иргэн хүсэлтээ гаргасаны 29 буюу 53.7 хувь нь одоо эзэмшиж, ашиглаж байгаа хашааныхаа газрыг өмчилж авах, 25 буюу 46.3 хувь нь шинээр газар өмчилж авах хүсэлт гаргасан байна. Хүсэлт гаргасан нийт иргэдийн хүсэлтийг 100 хувь

шийдвэрлэж, 7.8 га газрыг өмчлүүлсэн байна. Нийт иргэдийн өмчлөлд шилжсэн газрын 5 га буюу 64.1 хувь нь одооги йн эзэмшиж байсан газар нь, 2.8 га буюу 35.9 хувь нь шинээр олгогдсон газар байна.



II.6 Тээвэр

Авто тээврийн 2016 оны 1-р улиралд 3.2 мянган тонн ачаа тээвэрлэсэн ба ачаа тээврийн орлого 6385.5 мянган төгрөг байна. Дотоодод зорьсон зорьчигчдын тоо 2016 оны 1-р улирлын байдлаар 7.24 мянган хүн, зорьчигч эргэлт 2944.9 мянган хүн км, зорчигч тээврийн орлого 6524.6 байна.


Зураг II.7

Тээсэн ачаа, зорчигчдын тоо 1-р улирлын байдлаар



Холбоо

Шуудан холбооны салбарын орлого 2016 оны 1-р улиралд 129064.3 мянган төгрөг болж өмнөх оны мөн үеэс 10.1 хувиар буюу 14543.8 мянган төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна. Нийт орлогод хүн амаас орсон орлого 65998.3 мянган төгрөг байна.



II.7 Бизнес регистрын сан

Статистикийнзорилгоор ашигладаг аж ахуйн нэгж байгууллагын регистрийн санд 2016 оны эхний

3-р сард 1340 аж ахуйн нэгж бүртгэлтэй байгаагийн 1249 буюу 93.0 хувь нь үйл ажиллагаа явуулж байна. Регистрийн санд бүртгэлтэй, үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж байгууллагын 447 буюу 35.7 хувь нь Булган суманд ногдож байна

Стандарт хэмжил зүйн баталгаажилт

2016 оны 1-р улирлын байдлаар аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа худалдаа, үйлчилгээний тооцоо, хүн, мал эмнэлгийн шинжилгээ, эмчилгээ, оношилгоо, байгаль орчны хамгаалал эдгээрт ашиглагдаж байгаа нийт 285 ширхэг хэмжих хэрэгслийг стандартын дагуу баталгаажуулсан байна.

Үүнд: жин 45 ширхэг, цахилгаан тоолуур 195 ширхэг, даралтын аппарат 45 ширхэгийг баталгаажуулжээ.

Тайлант хугацаанд нийт 49 аж ахуй нэгж байгууллагуудад тохирлын гэрчилгээг олгосон байна. Үүнээс үйлчилгээний нэр төрлөөр нь авч үзвэл: Үсчин 1, халуун ус 1, саун 1, нийтийн тээвэр 4, нийтийн хоолны газар 5, дэлгүүр, бөөний худалдааны төв 37-н гэрчилгээ өгчээ.

Эх үүсвэр: Стандарт хэмжил зүйн хэлтсийн улирлын мэдээ



II.8 Хөдөө аж ахуй

Мал төллөлт, төл боожилт

Аймгийн хэмжээнд 2015 оны эцэст тоологдсон төллөх насны нийт 1444.7 мянган хээлтэгч малын 301.8 мянга буюу 20.9 хувь нь 2016 оны эхний улиралд төллөсөн байна. Эм ямааны 23.8 хувь, эм хонины 23.5 хувь, ингэний 5.2 хувь, үнээний 4.5 хувь, гүүний 0.6 хувь төллөжээ. Өмнөх оны мөн үетэй харьцуулвал 24.9 хувиар буурсан байна.

Гарсан төлийн 96.6 буюу 291.6 мянган төл бойжиж байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 26.6 хувиар буурсан байна.

Зүй бусын хорогдол

Том малын зүй бусын хорогдол 2016 оны эхний улиралд 33.1 мян.толгой болж, өмнөх оны мөн үеийнхээс 29.8 мян.толгой мал буюу 10.2 дахин хувиар өссөн байна. Нийт хорогдлыг малын төрлөөр авч үзвэл адуу 2.9 мянга буюу 9 хувь, үхэр 4.4 мянга буюу 13 хувь, хонь 13.6 мянга буюу 41 хувь, ямаа 12.2 мянга буюу 37 хувийг тус тус хорогдоод байна. Нийт хорогдлын дийлэнх 78 хувийг ямаа, хонь эзэлж байна. Хорогдлыг сумаар авч үзвэл

Рашаант сум 25.6 хувийг, Гурванбулаг сум 17 хувь, Дашинчилэн сум 13.5 хувь, Баяннуур сум 12.9 хувийг тус тус эзэлж байгаа нь дийлэнх болж байна. Өвчнөөр хорогдсон мал 211 болж өмнөх оны мөн үеийнхээс 150 толгой буюу 3.4 дахин өссөн байна.


Зураг II.6

Зүй бусаар хорогдсон том мал, сумаар, эхний улирлын байдлаар, толгой



Зураг II.7

Том малын зүй бусын хорогдол



Мал эмнэлэгийн үйлчилгээ

